



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 17




Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 3348 (24.0%) -аар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний хагас жилд 10595 болж, өмнөх оны мөн үеэс 3348 (24.0%) -аар буурчээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2995 (36.4%), хулгайлах гэмт хэрэг 2330 (60.4%), мал хулгайлах гэмт хэрэг 377 (51.4%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 202 (5.5%), дээрэмдэх гэмт хэрэг 139 (53.7%), хөрөнгө завших гэмт хэрэг 131 (44.6%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 126 (28.6%), хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 114 (29.6%) -өөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 198 (2.3 дахин) -аар өссөн байна.

Энэ оны 6 дугаар сард 1936 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 230 (13.5%) -аар өсөхөд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 140 (25.6%), өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 67 (8.1%), хулгайлах хэрэг 50 (20.5%) -аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 691 хэргийн 71 (10.3%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг) -ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2021 оны эхний хагас жилд 71 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13 (22.4%) -аар өсжээ. Харин 2021 оны 6 дугаар сард 20 бүртгэгдсэн нь өмнөх сарын түвшинд байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2021 оны эхний хагас жилд 4806 зөрчил бүртгэгдсэний 3545 (73.8%) зөрчлийг шалган шийдвэрлэжээ.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 1087 (18.4%) -гоор, шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил 1146 (24.4%) -гаар тус тус буурчээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний хагас жилд 49 болж, өмнөх оны мөн үеэс 16 (24.5%) -гаар буурсан байна. Харин 2021 оны 6 дугаар сард өмнөх сараас 1 (12.5%) -ээр өсжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг 2021 оны эхний хагас жилд 691 болж, өмнөх оны мөн үеэс 124 (21.9%-өөр, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 77 болж, 1 (1.3%-ээр нэмэгдэж, харин согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2135 болж, өмнөх оны мөн үеэс 97 (4.3%-гоор, эмэгтэй хүн оролцсон хэрэг 1572 болж, 53 (3.3%-аар, бүлэглэн үйлдсэн хэрэг 587 болж, 292 (33.2%-оор, хүүхэд оролцсон хэрэг 265 болж, 27 (9.2%-гоор тус тус буурчээ.

Зураг 2. Учирсан хохирол, нөхөн төлүүлсэн хохирол, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2021 оны эхний хагас жилд 85.6 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 39.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 5.4 (6.0%) тэрбум төгрөгөөр буурч, харин нөхөн төлүүлсэн хохирол 17.6 (80.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Гэмт хэргийн улмаас хохирсон, гэмтсэн, нас барсан хүн, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

| Үзүүлэлт | Хохирсон хүн | | Гэмтсэн хүн | | Нас барсан хүн | |
|------------------------|--------------|-----------|-------------|-----------|----------------|-----------|
| | 2020 I-VI | 2021 I-VI | 2020 I-VI | 2021 I-VI | 2020 I-VI | 2021 I-VI |
| 7 хүртэлх | 68 | 69 | 23 | 33 | 33 | 19 |
| 8-17 | 500 | 414 | 169 | 162 | 26 | 10 |
| 18-29 | 3 491 | 2 735 | 1 235 | 1 040 | 50 | 48 |
| 30-39 | 4 432 | 3 367 | 1 313 | 1 208 | 72 | 73 |
| 40-49 | 2 898 | 2 168 | 743 | 712 | 85 | 59 |
| 50-59 | 1 623 | 1 057 | 399 | 368 | 74 | 50 |
| 60-69 | 567 | 346 | 105 | 102 | 30 | 13 |
| 70, түүнээс дээш насны | 120 | 103 | 17 | 41 | 11 | 8 |
| Улсын дүн | 13 699 | 10 259 | 4 004 | 3 666 | 381 | 280 |
| Эмэгтэй | 5 688 | 4 672 | 1 549 | 1 384 | 100 | 77 |


Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2021 оны эхний хагас жилд 10.3 мянга болж, 483 (4.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 4672 (45.5%) нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний хагас жилд 3666 хүн гэмтэж, 280 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 338 (8.4%-аар, нас барсан хүн 101 (26.5%-ээр буурчээ.

Гэмт хэргийн улмаас 2021 оны эхний хагас жилд хохирсон 10259 хүний 69 (0.7%) нь 7 хүртэлх насных, 414 (4.0%) нь 8-17 насных, 2735 (26.7%) нь 18-29 насных, 3367 (32.8%) нь 30-39 насных,

2168 (21.1%) нь 40-49 насных, 1506 (14.7%) нь 50, түүнээс дээш насныхан байна.

Зураг 3. Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, насны бүлгээр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2021 оны эхний хагас жилд 7467 болж, өмнөх оны мөн үеэс 942 (11.2%)-оор буурчээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 303 (4.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 1298 (17.4%) нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэрэгт 2021 оны эхний хагас жилд холбогдсон нийт 7467 яллагдагчийн 94 (1.2%) нь 14-15 насных, 209 (2.8%) нь 16-17 насных, 2828 (37.9%) нь 18-29 насных, 2202 (29.5%) нь 30-39 насных, 1530 (20.5%) нь 40-49 насных, 604 (8.1%) нь 50, түүнээс дээш насных байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний хагас жилд 34.3 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 7.2 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 17.4 (33.7%) мянгаар, баривчлагдсан хүн 1.5 (17.5%) мянгаар буурсан байна.


Авлигатай тэмцэх газарт 2021 оны эхний хагас жилд 181 авлигын хэрэг бүртгэгджээ.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2021 оны эхний хагас жилд авлигын 181 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 (1.6%)-аар буурчээ. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс буурахад хахууль өгөх гэмт хэрэг 6 (27.3%)-гаар, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг 7 (77.8%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ.

Харин 2021 оны 6 дугаар сард 37 авлигын хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 12 (48.0%)-оор өссөн байна. Бүртгэгдсэн авлигын хэрэг өмнөх сараас өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 7 (35.0%)-гоор, хахууль авах гэмт хэрэг 6 (3.0 дахин)-гаар, хахууль өгөх гэмт хэрэг 5 (6.0 дахин)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 181 авлигын хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 140 (72.2%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 33 (17.0%) нь хахууль авах гэмт хэрэг, 16 (8.2%) нь хахууль өгөх хэрэг, 2 (1.0%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 3 (1.5%) хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг байна.

Зураг 4. Авлигын гэмт хэрэг, хэргийн төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Авлигын гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт зааснаар авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт үйлдлүүдийг хамруулна.

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл

Ангилал, код: Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

Мэдээлэл авах линк:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 17

Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805

Хүн ам, нийгмийн статистикийн
газрын статистикч Ц.Дулмаа
Утас: (976-51)-263966

